



**ЗАМ, ТЭЭВРИЙН
ЯАМ**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**ДАЛАЙН ЗАХИРГААНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2025 он



**ДАЛАЙН ЗАХИРГААНЫ 2025 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**
(жилийн эцсийн байдлаар)

2026.02.02

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Далайн захиргааны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

Далайн захиргааны 2025 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайдын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 93.3%-тай байна. /Хүснэгт 1/

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Нийт	Үүнээс				Хэрэгжилтийн хувь
	100%	Хэрэгжих шатанд	0%	Хугацаа болоогүй	
52	41	11	-	-	93.6%

Хэрэгжилт хангалтгүй 7 арга хэмжээ:

№	Арга хэмжээний заалт, агуулга	Зорилтот түвшин	Хугацаа	Биелэлт	%
1	1.6 Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Далайн хөдөлмөрийн тухай” конвенцын хэрэгжилтийн тайланг боловсруулж, холбогдох	Холбогдох байгууллагад хүргүүлэх	IV улиралд	Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/42 дугаар тушаалаар Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Далайн хөдөлмөрийн тухай” конвенцын хэрэгжилтийн тайланг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.	30

	байгууллагад хүргүүлэх			Ажлын хэсэг "Далайн хөдөлмөрийн тухай" конвенцын хэрэгжилтийн тайлангийн төслийг боловсруулсан. "Далайн хөдөлмөрийн тухай" конвенцын хэрэгжилтийн тайланг удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэхээр орчуулгын ажил хийгдэж байна.	
2	2.2 Далбааны эзэн улсын гэрээт хянан шалгагчийн тоог нэмэгдүүлэх	5	IV улирал	Монгол Улсын Далайн захиргаатай далбааны эзэн улсын хяналт шалгалт хэрэгжүүлэх асуудлаар хамтран ажиллах хүсэлт ирүүлсэн 5 иргэний холбогдох бичиг баримт, ажлын туршлага зэргийг судлан хамтран ажиллах гэрээ байгуулахад бэлэн болоод байна. Турк улсад Сердар Кандемир, Малайз болон Сингапур Улсад Тум Бан Ший, БНСУ-ын Бусан боомтод Сионг Сиог Лий, Турк болон Шенгений орнуудын боомтод Онур Караман, Энэтхэг болон АНЭУ-д Санжой Яакоб зэрэг далайн салбарт 10-20 жил ажилласан дадлага туршлагатай мэргэжлийн боловсон хүчнийг Монгол Улсын гэрээт хянан шалгагчаар томилж хамтран ажиллах гэрээ байгуулахад бэлтгэж байна. Хамтран ажиллах гэрээний төсөл эцэслэн батлагдах асуудал хүлээгдэж байна. Монгол Улсын Далайн захиргаатай далбааны эзэн улсын хяналт шалгалт хэрэгжүүлэхээр хамтран ажиллах хүсэлт ирүүлсэн 5 иргэний холбогдох бичиг баримт, ажлын туршлага зэргийг судлан хамтран ажиллах гэрээ байгуулахад бэлэн болоод байна. Гэрээнд эрх зүйн талаас өөрчлөлт оруулах саналаа хүргүүлсэн. Хариу хүлээгдэж байна.	50
3	5.11 Ёс зүй, мэдлэг чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх, сургалтууд зохион байгуулах	100	IV улирал	Далайн захиргааны 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар "Сургалтын хөтөлбөр" баталж Зам, тээврийн яамнаас зохион байгуулсан нийт 5 сургалтад 15 холбогдох мэргэжилтнүүдийг хамруулсан. Үүнд: "Мета өгөгдлийн сан" сэдэвт сургалтад 4 ажилтан, "Байгууллагын мэдээллийн аюулгүй байдал"-ын сургалтад 3 ажилтан, "Мэдээлэл технологийн	50

				Кибер аюулгүй байдал"-ын сургалтад 1 ажилтан, Улсын /ахлах/ байцаагч нарын чадавхжуулах сургалтад 6 улсын байцаагч, Хүний нөөцийн ажилтнуудын сургалтад 1 ажилтан, ХАБЭА-н дүрэм, журам болон онцгой байдлын үед үзүүлэх анхны тусламж, гамшгаас урьдчилан сэргийлэх, осолд өртөгсдөд үзүүлэх анхны тусламжийн сургалтад нийт ажилтнууд тус тус хамрагдсан.	
4	1.1 Усан замын тээврийн тухай хуулийг шинэчлэх төслийн саналыг боловсруулж Зам, тээврийн яаманд хүргүүлэх	Хүргүүлсэн байна.	IV улирал	Хуулийн төслийн саналыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар байгуулсан. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавихад тулгардаг нийтлэг хүндрэл бэрхшээл, усан замын тээврийн аюулгүй байдлыг сайжруулах зохицуулалтуудын талаар төсөлд санал авах зорилгоор 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Зам, тээврийн яамны Салбарын хяналтын газрын болон орон нутаг дахь усан замын тээврийн хяналтын улсын /ахлах/ байцаагчдыг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулсан. 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгуулсан "Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа" сэдэвт сургалт семинарын үеэр усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн дунд хэлэлцүүлэг мөн зохион байгуулсан. Салбарын төрийн бус байгууллагуудын (Монголын завьчдын нэгдсэн холбоо, Монголын сэлүүрт завины холбоо, Монголын Рафтингийн холбоо) төлөөлөл, удирдлагуудтай уулзалтуудыг хийсэн. Дээрх хэлэлцүүлэг, уулзалтын үеэр гарсан саналыг төсөлд тусгасан бөгөөд аргачлалын дагуу хуулийн төслийг боловсруулалтын ажил хийгдэж байна. Хуулийн төслийг боловсруулж 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдөр хүлээлгэн өгөх гэрээ байгуулан ажиллаж байна.	70
5	2.5 Усан замын тээврийн үйлчилгээ	40	IV улирал	Тусгай зөвшөөрөл авахаар нийт 58 хүсэлтийг цахимаар хүлээн	70



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

	эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах баримт бичгийн бүрдлийг хүлээн авах, шалгах, хүсэлтийг шийдвэрлэх			авч, хянаж шаардлага хангаагүй, буруу болон материал дутуу илгээсэн 32 хүсэлтийг буцааж, 26 хүсэлтийг Зам, тээврийн яаманд хүргүүлж, шийдвэрлүүлсэн.	
6	3.6 Олон улсын хуурай боомтын төлөвлөлт, бүтээн байгуулалтын чиглэлээр сайн туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээ авч ажиллах	100	IV улирал	БНСУ-ын Далайн хэрэг, загас агнуурын яамны урилгаар “Бидний далай 2025” олон улсын хуралд Далайн захиргааны төлөөлөл оролцсон ба тус улсын “Логистикийн байгууламжийн хөгжүүлэлт, удирдлагын тухай” хуулийн талаар холбогдох судалгааг хийсэн. БНХАУ, Сингапур Улс, БНСУ, Европын холбогдох стандарт, эрх зүйн орчны талаар орчуулан судалсан. БНХАУ-ын Шаньдун мужийн Рижэо далайн боомтод 2025 оны 05 дугаар сарын 13-16-ны өдрүүдэд тус боомтод ажиллаж туршлага судалсан. НҮБ-ын АНДЭЗНК-аас Хойд, Төв Азийн дэд бүс болон Монгол Улсад зориулан зохион байгуулсан “Хуурай боомтууд болон тэдгээрийг олон төрлийн тээврийн сүлжээнд нэгтгэх цахим хэрэгслүүдийн хөгжүүлэлт” сэдэвт семинарт 2025 оны 06 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд цахимаар хамрагдсан. ӨМӨЗО-ны Нийгмийн шинжлэх ухааны академитай байгуулсан Санамж бичгийн хүрээнд Монгол Улсад хийх судалгааны урьдчилсан хөтөлбөрийг боловсруулан санал солилцох уулзалтыг 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж, цаашид хамтран ажиллах талаар санал солилцсон. Мөн БНХАУ-ын Шанхай хотод байрлах Дэлхийн яаралтай аврах байгууллагын сургалтад (WERO) 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр хамрагдсан. Гадаад харилцааны яам болон НҮБ-ын Нэн буурай хөгжилтэй, Далайд гарцгүй хөгжиж буй болон Арлын жижиг орнуудын асуудал эрхэлсэн Дээд төлөөлөгчийн газар (UN-OHRLLS) хамтран зохион байгуулж буй “Далайд гарцгүй хөгжиж буй улс орнуудын олон улсын худалдаа ба тээврийн	70

				бодлого боловсруулах” сэдэвт үндэсний сургалтад 2025 оны 12 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд 2 төлөөлөгч оролцсон болно. “Хуурай боомт болон далайн боомтын холболтын чиглэлээр байгуулсан санамж бичгийн хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-нд нийт 4 ажил тусгагдсан бөгөөд хэрэгжилт 85%-тай. “2025 оны сургалтын төлөвлөгөө”-нд нийт 6 ажил тусгагдсан бөгөөд хэрэгжилт 100%-тай байна.	
7	6.2 Байгууллагын сүлжээ, программ хангамжийн аюулгүй байдлын төлөвлөгөө гаргаж, эрсдэлийн үнэлгээ хийх	2	III-IV улирал	2025 оны 02 дугаар сард төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу байгууллагын 40 ширхэг компьютерт албан ёсны эрхтэй үйлдлийн систем, хэрэглээний программ суулгасан. Мөн вирусийн хамгаалалт ба системийн аюулгүй байдал хүрээнд байгууллагын 40 ширхэг компьютерт антивирусний программ суулгаж, нийт 29 компьютерыг форматалсан. Сүлжээний хяналтыг тогтмол хийж, тайлант хугацаанд нийт 21 компьютерын сүлжээний утсыг холбосон байна. Мэдээллийн аюулгүй байдлын аудит, эрсдэлийн үнэлгээний “Кибер шилжилт” ХХК-тай гэрээ байгуулан эрсдлийн үнэлгээ хийлгэсэн. Аудитын зөвлөмжийн дагуу “Женералтеч” ХХК-иар байгууллагын дотоод сүлжээг шинэчлэн зохион байгуулсан.	70

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
2	2	-	-	-	-	100.0

2.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
20	18	2	-	-	-	95.0



Хэрэгжих шатанд байгаа 2 арга хэмжээ:

1/Монгол-Солонгосын хамтарсан “Монгол Саммок Ложистик” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай 2025.02.11 А/33

2. Хамтарсан компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шинэчлэн томилогдсон Монголын талын бүрэлдэхүүний талаар хамтрагч БНСУ-ын талд мэдэгдэж, холбогдох бүртгэлийг хийлгүүлэх талаар арга хэмжээ авч ажиллахыг Далайн захиргаа (Б.Сайнбаяр)-д

Биелэлт: Төлөөлөн удирдах зөвлөлийг шинэчлэн томилогдсон бүрэлдэхүүний бүртгэлийг хийлгэх ажлыг зохион байгуулж ажиллахад хамтарсан компанийн Солонгосын талаас дараах тайлбарыг өгсөн болно. Хамтарсан компанийн үйл ажиллагаа эхлээгүй буюу Монгол Улс нүүрсээ гуравдагч оронд худалдан борлуулах, түүнтэй холбоотойгоор хөрш орны далайн боомтод хүргэх ажлыг авч хэрэгжүүлээгүй нөхцөл байдлын улмаас уг хамтарсан компанийн бизнесийн үйл ажиллагаа эхлэх боломжгүй хүлээгдэж байгаа нөхцөлд төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дахин дахин солих үйл явц нь хүндрэлтэй байгаа талаар мэдэгдсэн. Уг хамтарсан компанийн үйл ажиллагааг эхлүүлэх нөхцөл бүрдсэн үед БНСУ-ын бүртгэлийн байгууллагад өөрчлөлтийг бүртгүүлэх ажлыг авч хэрэгжүүлэхийг зөвлөсөн болно. Учир нь БНСУ-ын бүртгэлийн байгууллагын холбогдох дүрэм, журмын хүрээнд бүртгэлийг өөрчлөхөд хуулийн нилээдгүй үйл явц тулгардаг талаар мэдэгдээд Монголын талаас үйл ажиллагаа нь эхлээгүй энэхүү компани дээр дахин дахин өөрчлөлт хийлгэхийг шаарддаг байдал нь хүндрэлтэй байгааг илэрхийлсэн болно.

2/ Монгол-Солонгосын хамтарсан “Монгол Саммок Ложистик” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай 2025.02.11 А/33

3.“Монгол Саммок Ложистик” ХХК-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд даалгасугай

Биелэлт: Төлөөлөн удирдах зөвлөлийг шинэчлэн томилогдсон бүрэлдэхүүний бүртгэлийг хийлгэх ажлыг зохион байгуулж ажиллахад хамтарсан компанийн Солонгосын талаас дараах тайлбарыг өгсөн болно. Хамтарсан компанийн үйл ажиллагаа эхлээгүй буюу Монгол Улс нүүрсээ гуравдагч оронд худалдан борлуулах, түүнтэй холбоотойгоор хөрш орны далайн боомтод хүргэх ажлыг авч хэрэгжүүлээгүй нөхцөл байдлын улмаас уг хамтарсан компанийн бизнесийн үйл ажиллагаа эхлэх боломжгүй хүлээгдэж байгаа нөхцөлд төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дахин дахин солих үйл явц нь хүндрэлтэй байгаа талаар мэдэгдсэн бөгөөд. Уг хамтарсан компанийн үйл ажиллагааг эхлүүлэх нөхцөл бүрдсэн үед БНСУ-ын бүртгэлийн байгууллагад өөрчлөлтийг бүртгүүлэх ажлыг авч хэрэгжүүлэхийг зөвлөсөн болно. Учир нь БНСУ-ын бүртгэлийн байгууллагын холбогдох дүрэм, журмын хүрээнд бүртгэлийг өөрчлөхөд хуулийн нилээдгүй үйл явц тулгардаг талаар мэдэгдээд Монголын талаас үйл ажиллагаа нь эхлээгүй энэхүү компани дээр дахин дахин өөрчлөлт хийлгэхийг шаарддаг байдал нь хүндрэлтэй байгааг илэрхийлсэн болно.

2.4. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ:



Д/д	Үзүүлэлтийн бүлэг	Үнэлгээ (хувь)
1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	68.5
2	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	73.2
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	83.8
4	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх ил тод, нээлттэй байдал	75.8
5	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	48.3
Дүн		73.5

Хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээ:

1/ 8.2.2 Хаяг, байршил, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг 30%,

2/ 8.2.4 Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан 0%,

3/ Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ 30%,

4/ 8.4.23 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулсан тухай бүрд хувийн хэвшлийн түншлэгч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, түншлэлийн зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл (Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага) 0%,

5/ 8.5.2 Олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл 30%,

6/ 8.1.6 Бусад байгууллага, иргэнээс өгсөн санал 0%,

7/ 8.6.5 Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг 30%,

8/ 8.6.9 Хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагавар, тэдгээрийг арилгах арга хэмжээг тогтоосон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаарх мэдээлэл, газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн мэдээлэл (Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага) 30%.

2.5. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл оруулах тоо	Мэдээлэл оруулсан тоо	Үүнээс:			Гүйцэтгэлийн хувь
		Хугацаан-даа	Хоцорсон	Мэдээлээ-гүй	
180	180	176	4	-	97.8

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

Төлөвлөлтийн байдал:

Далайн захиргааны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээний зорилтот түвшнийг улирал бүрээр төлөвлөөгүй байна. /1.3, 2.4, 3.4, 4.1, 6.2, 6.5, 7.1, 8.1-8.3, 9.2/

Хөлөг онгоцны бүртгэлийн гэрчилгээг цахимаар олгох ажлыг 2025 оны эхний хагас жилд 200 гэрчилгээ олгохоор төлөвлөсөн боловч Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгүүлсэн хөлөг онгоцонд нийт 2926 бүртгэлийн гэрчилгээ олгосон нь төлөвлөлтийн үе шатанд шаардлагатай судалгаа, тооцоолол дутуу хийгдсэнээс үүдсэн төлөвлөлтийн алдаа болох нь харагдаж байна. Цаашид бодит хэрэгцээ, урьдчилсан тооцоонд тулгуурлан илүү нарийвчилсан төлөвлөлт хийх шаардлагатай байна.

Хэрэгжилтийн байдал:

1) Далайн захиргааны 2025 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайдын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 93.3%-тай байна.

2) Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Далайн хөдөлмөрийн тухай" конвенцын хэрэгжилтийн тайлангийн орчуулгыг бүрэн дуусгаагүй байна.

3) Байгууллагын сүлжээ, программ хангамжийн аюулгүй байдлын төлөвлөгөө гаргаж, эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн талаарх нотлох баримтыг хангалтгүй ирүүлсэн.

4) Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 56 арга хэмжээний хэрэгжилт 93.6% байна. Үүнээс 78.8% нь хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн болон хүрэх шатандаа, 21.2% нь төлөвлөсөн үр дүндээ бүрэн хүрээгүй байна.

5) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

Зорилт	Зорилтот түвшин	Хэрэгжилтийн хувь
Зорилт 1: Далайн болон усан замын тээврийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэн боловсруулна.	1	85.7
Зорилт 2: Далайн болон усан замын тээврийн үйл ажиллагааг сайжруулна.	50	82.0
Зорилт 3: "Хуурай боомтын тухай засгийн газар хоорондын хэлэлцээр"-т тусгагдсан байршлуудад хуурай боомтыг үе шаттай байгуулна.	70	94.3
Зорилт 4: Хоёр болон олон талт хамтын ажиллагааг хөгжүүлж, олон улсын хурал санаачлан зохион байгуулна.	5	100
Зорилт 5: Монгол Улсын Далайн захиргааны хэвийн үйл ажиллагааг хангана.	5	94.6
<u>Зорилт 6: Байгууллагын үйлчилгээний чанарыг сайжруулах</u>	60	94.0
Зорилт 7: <u>Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлнэ.</u>	4.5	100.0
<u>Зорилт 8: Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гарган, хэрэглэгчдийг мэдээллээр хангана.</u>	5	100.0
Зорилт 9: Салбарын хүний нөөцийг бэлтгэж, төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангана.	5	100.0
Зорилт 10:	4.5	100.0



Далайн болон усан замын тээврийн салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжлийн зөвлөгөөгөөр ханган дэмжлэг үзүүлж ажиллах		
---	--	--

6) Тус байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж өгсөн 8 зөвлөмжөөс дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй, удаашралтай байна. Үүнд:

- Далбааны эзэн улсын гэрээт хянан шалгагчийн тоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд хамтран ажиллах хүсэлт ирүүлсэн хянан шалгагчидтай байгуулах гэрээний төслийн талаар санал авах, хөгжүүлэлт хийх үйл явцыг шуурхай зохион байгуулж, санал солилцох ажиллагааг эрчимжүүлэх;

- Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр авах, сунгуулахтай холбоотой иргэдийн ирүүлсэн хүсэлт, баримт бичгийг хүлээн авч, шаардлага хангуулах талаар зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн, шийдвэрлэх боломжийг эрэлхийлж, төлөвлөсөн зорилтот түвшинд хүргэн хэрэгжилтийг ханган ажиллах;

- “Монгол Саммок Ложистик” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Монголын талын шинэчилсэн бүрэлдэхүүнийг холбогдох байгууллагад мэдэгдэн бүртгэлжүүлэх ажлыг яаравчлан хэрэгжүүлэх;

- Хариуцан хэрэгжүүлж байгаа арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа дэвшүүлсэн зорилтын хүрээнд монгол хэлний үг үсгийн алдаагүй, зохион байгуулсан гол ажлаа хүрсэн үр дүн, зорилтот түвшин, хэрэгжүүлэх хугацаатай нь уялдуулан тайлагнаж хэвших;

7) Яам, тээврийн яамнаас 2025 оны 10-11 сард яам болон харьяа байгууллагуудын “Хяналт шалгалт болон аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт-д дотоод аудит хийж, Далайн захиргааны хэрэгжилт 50.0 хувь буюу хангалтгүй үнэлэгдсэн байна.

Хяналт шалгалт, аудит, хяналт- шинжилгээ хийсэн байгууллага	Акт, албан шаардлага, зөвлөмжийн тоо			Хувь
	Нийт	Үүнээс		
		Хэрэгжсэн	Хугацаа болоогүй	
ҮАГ	12	6	-	50.0%

Энэ нь зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс гадна хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг боловсруулахдаа хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой тодорхойлоогүй, хугацааг бодитой тооцоолоогүй, хариуцах эзэн нь тодорхой бус төлөвлөсөн, хэрэгжилтийг баримтад суурилан тайлагнаагүй, нотлох баримтыг хавсарган ирүүлээгүй зэргээс шалтгаалсан байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа төлөвлөлтийн үе шатанд шаардлагатай судалгаа, тооцоолол хийж, бодит хэрэгцээ, урьдчилсан тооцоонд тулгуурлан төлөвлөх;

2. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Далайн хөдөлмөрийн тухай” конвенцын хэрэгжилтийн тайлангийн орчуулж, холбогдох байгууллагад хүргүүлэх;

3. Далбааны эзэн улсын гэрээт хянан шалгагчийн тоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд хамтран ажиллах хүсэлт ирүүлсэн хянан шалгагчидтай байгуулах



гэрээний төслийн талаар санал авах, хөгжүүлэлт хийх үйл явцыг шуурхай зохион байгуулж, санал солилцох ажиллагааг эрчимжүүлэх;

4. "Монгол Саммок Ложистик" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Монголын талын шинэчилсэн бүрэлдэхүүнийг холбогдох байгууллагад мэдэгдэн бүртгэлжүүлэх ажлыг яаравчлан хэрэгжүүлэх;

5. Байгууллагын сүлжээ, программ хангамжийн аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийлгэх;

6. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, байгууллагын цахим сайтад ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн мэдээллийг цаг тухайд нь байршуулан хөгжүүлэлт хийхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

7. Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулж, хэрэгжилтийг хангах төлөвлөгөө боловсруулан, уг төлөвлөгөөний биелэлтийг холбогдох байгууллагуудад тогтоосон хугацаанд нотлох баримт, материалын хамт бүрэн тайлагнадаг тогтолцоог хэвшүүлэх;

8. Бүрэн хэрэгжсэн ч тогтмол зохион байгуулагддаг арга хэмжээний биелэлтийг улирал бүр шинэчилж, монгол хэлний зөв бичгийн дүрмийн алдаагүй, товч, тодорхой, тоо баримт, огноог тодорхой дурдан нотлох баримтын хамт ирүүлж хэвших;

ТАНИЛЦСАН:
САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

ДЭД САЙД

Т.ГАНБОЛД

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА

Б.БОЛОР-ЭРДЭНЭ

БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.БАЯНЗУЛ

ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГА

М.ӨЛЗИЙ

ХЯНАСАН:

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ОЮУНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:
САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Л.ШИНЭЧИМЭГ

**ДАЛАЙН ЗАХИРГААНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**
(жилийн эцсийн байдлаар)

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Хэрэгжилтийн хувь	Жинлэсэн хувь
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	52	52	93.6	20
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	2	2	100.0	20
3	Сайдын тушаалын хэрэгжилт	20	20	95.0	10
4	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	52	52	73.5	10
5	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	180	180	97.8	10
Нийт		306	306	93.3	